

# МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр  
сарын 21-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

## Мал хамгаалах санд хийсэн дотоод аудитын дүнг хэлэлцсэн тухай

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн тушаалаар батлагдсан ажлын хэсгийн Мал хамгаалах санд хийсэн дотоод аудитын тайлан дүгнэлтийг танилцуулав.

Мал хамгаалах санд хийсэн дотоод аудитын дүгнэлтээр улсын төсвийн санхүүжилт, авлага, мал аж ахуйн бодлогын арга хэмжээний хэрэгжилт, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах, бүртгэх, зээлийн эргэн төвлөрүүлэлт зэрэг ажлууд нь хангалтгүй хэрэгжсэн, дээрх ажлуудыг гүйцэтгэхдээ хууль, дүрэм зөрчсөн нь тогтоогдсон байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3 дахь /Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах бэлэглэх барьцаалах, зээлдүүлэх бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно/ заалтыг зөрчсөн Мал хамгаалах сангийн “АТААСҮ” ХХК-тай 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан Б-2013/01 дугаартай “2013/01 тоот зээлийн барьцааны гэрээ” болон “Бага-Өлгий” ХХК-тай 2014 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан “Б-2014/01” дугаартай зээлийн барьцааны гэрээт ажлуудыг холбогдох хуулийн байгууллагад хандаж шалгуулахыг Хуулийн хэлтэс /Б.Батцэцэг/-т үүрэг болгосугай.

2. “АТААСҮ”, “Бага-Өлгий”-ХХК-тай байгуулсан барьцааны гэрээ, “Гацуурт” ХХК-тай гэрээ байгуулах, дүгнэх явцад хариуцлага алдаж, зөрчил гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох асуудлыг судалж шийдвэрлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Баяртулга/-д үүрэг болгосугай.

3. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Мал хамгаалах сангаас “АТААСҮ” ХХК-тай байгуулсан 2013/01 дугаартай гэрээний дагуу 144 толгой хээлтүүлэгч, 176 толгой хээлтэгчийг 2015, 2016 онд хүлээлгэн өгөх тухай гэрээний 2.2, 2.5 болон 5.3 дахь заалтуудыг зөрчсөн гэрээг 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор дүгнэх ажлын хэсэг томилж гэрээний гүйцэтгэлийг хангуулах,

- Сүхбаатар аймгийн “Бага-Өлгий” ХХК-тай “Хонь бордох загвар аж ахуй бий болгох” төсөлд дэмжлэг үзүүлэх АГГ-140520/03-045 дугаартай 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн зээлийн гэрээний 3.4-т заасан гэрээ дүгнэх актыг 2015, 2016 онд үйлдээгүй зөрчлийг арилгаж гэрээг дүгнэх,

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Мал хамгаалах сантай “Гацуурт” ХХК-ийн байгуулсан “ЭМААХДХ”-2011/07 дугаартай зээлийн гэрээний зээл төлөх хуваарь зөрчсөн, гэрээ дүгнээгүй зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор хэрэгжүүлж, гүйцэтгэлийг тайлагнахыг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Чой-Иш/, Мал хамгаалах сан /Б.Ганзориг/-т, заасан хугацаанд гэрээний үүргийн биелэлтийг хангуулаагүй тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлыг судалж шийдвэрлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Баяртулга/-т үүрэг болгосугай.

4. Хавсралтад дурдсан Мал хамгаалах сангийн үйл ажиллагаа, ажлын үр дүнг сайжруулах тухай аудитын зөвлөмжид Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон сантай холбоотой гэрээнүүдийн зөрчлийг арилгах, түрээсийн гэрээг сунгах, цуцлах асуудлыг шийдвэрлэх, агуулах дахь зарим бараа материал, эвдэрхий тоног төхөөрөмжүүдийг актлах, худалдах, хуваарилах, түрээсээр эзэмшүүлэх арга хэмжээ авах, зээлдэгчдийн нэгдсэн бүртгэл бий болгох, эрсдлийг тооцох, хугацаа хэтэрсэн зээлийн гэрээг шүүхэд шилжүүлэх, авлагыг бууруулах арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

5. Зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан 2016 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Чой-Иш/, Мал хамгаалах сангийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Ганзориг/ нарт үүрэг болгосугай.

6. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналтад авч, хагас бүтэн жилээр Дотоод аудитын хороонд тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Совд/-д үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ДОТООД  
АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

П.СЭРГЭЛЭН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төсвийн ерөнхийлөн захирагчийн “Дотоод аудитын хороо”-ны 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт

## **МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЖЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ ТАЛААР ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ТУХАЙ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 09 дугаар сарын 08-ны өдрийн удирдамжийн дагуу Мал хамгаалах сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, улсын төсвийн санхүүжилт, авлага, мал аж ахуйн бодлогын арга хэмжээний хэрэгжилт, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах, бүртгэх, зээлийн эргэн төвлөрүүлэлт, ажлын үр дүнд өгсөн дүгнэлтэд үндэслэн дотоод аудитын ажлын хэсгээс дараах зөвлөмжийг гаргаж байна.

### **НЭГ. ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГАД**

1.1. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй төсвийн байгууллагын болон Яамны дотоод журамд аливаа гэрээ, хэлцэл, шийдвэрийг гаргах, баталгаажуулах эрх бүхий албан тушаалтныг тодорхой зааж, тэдгээртэй хэрхэн хариуцлага тооцож байх талаарх холбогдох заалтуудыг тодорхой тусгах,

1.2. ХХААХҮ-ийн сайдын тушаал шийдвэрт дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар тодорхой заалтуудыг тусгаж байх,

1.3. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулж буй худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хороо болон хэрэгжилтийг зохион байгуулах, хүлээн авах ажлын хэсэгт тогтмол Мал хамгаалах сангаас төлөөлөл оролцуулж байх,

1.4. Холбогдох хууль, эрх зүйн хүрээнд нийцүүлэн Мал, аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Аймаг дундын отрын бүс нутгийн ашиглалтын захиргаа болон Мал хамгаалах сангийн үндсэн чиг үүргийн давхардлыг арилгах санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулах,

### **ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАРТ**

2.1. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй төсвийн байгууллагын болон Яамны дотоод журамд аливаа гэрээ, хэлцэл, шийдвэр гаргах, баталгаажуулах эрх бүхий албан тушаалтныг тодорхой заах, хэрхэн хариуцлага тооцох талаар санал боловсруулан шийдвэрийн хэрэгжилтэд дотоод хяналт тавих,

2.2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаар Мал хамгаалах сангийн үндсэн чиг үүргийг гүйцэтгүүлэх, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусгах,

2.3. “Иргэний тухай” хуулийн 312 дугаар зүйлийг үндэслэн Санхүүгийн түрээсийн (лизинг) гэрээнд бараа, эд хөрөнгийн ашиглалт, эзэмшилтийн асуудлыг тодорхой тусган оруулахад нь хууль, эрх зүйн зөвөлгөө өгөх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх,

2.4. Мал аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах байгууллагуудын үндсэн чиг үүргийг хуульд заасан хүрээнд давхардлыг арилгах, өөрчлөн зохион байгуулах санал боловсруулан 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх,

## **ГУРАВ. БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАРТ**

3.1. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад баталсан төвлөрсөн арга хэмжээ болон хөрөнгө оруулалттай холбоотой тушаал, шийдвэрт хөрөнгийн бүртгэлийн асуудлыг тодорхой тусгах,

3.2. Мал хамгаалах санг эрх зүйн хүрээнд бүрэн чадамжтай болгох талаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх ажлыг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулах,

3.3. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад батлагдсан төвлөрсөн болон хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардлаар гүйцэтгэсэн худалдан авах ажиллагаа болон бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах ажлын хэсэгт Мал хамгаалах сангийн төлөөллийг 2017 оноос эхлэн оролцуулах арга хэмжээ авах,

3.4. Бараа материалын дансанд бүртгэгдсэн лизингийн гэрээг хугацааны эцэст үлдэх өртөггүйгээр гэрээ байгуулсан тохиолдолд НББОУСтандартын 2-т зааснаар эзэмшигч, ашиглагчдад шууд шилжүүлэхээр тусгах болон тухай бүр төлбөр гүйцэтгэсэн үнийн дүнгээр данснаас хасах талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгах,

3.5. Салбарын төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх,

3.6. Улсын төсвийн санхүүжилтээс Тусгай сангуудаар дамжуулан олгосон зээл, түүний хүүг тооцох, зээлийг ангилан бүртгэх тухай НББ-ийн бодлогын баримт бичигт тусгах, авлагыг бууруулах арга хэмжээг холбогдох хууль, тогтоомж, журам, дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлэх.

## **ДӨРӨВ. МАЛ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАРТ**

### **4.1. “Усны өрөмдлөгийн машины иж бүрдэл”-ийн түрээсийн гэрээний талаар**

4.1.1 Увс аймгийн “Ус-Эрдэнэ” ХХК-тай 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан 2013/01 дугаартай Түрээсийн гэрээг Увс аймгийн Засаг дарга, Төрийн өмчийн хороо, Мал хамгаалах сан хамтран дүгнэж, бүртгэлээс хасч худгийн өрөмдлөгийн машины иж бүрдлийг түрээслэгчид шилжүүлэн өгөх болон гарсан худгуудыг орон нутгийн өмчид бүртгүүлэх,

4.1.2 Завхан аймгийн “Тэсийн бүрд”, Баянхонгор аймгийн “Чорьж бүрд”, Ховд аймгийн “Эвлэл” компаниудтай байгуулсан Түрээсийн гэрээнүүдийг Завхан, Баянхонгор, Ховд аймгийн Засаг дарга, Төрийн өмчийн хороо, Мал хамгаалах сан хамтран дүгнэж, 2013, 2014, 2015 онуудад гүйцэтгэсэн ажлыг үнэлэн, тайлангуудыг хянан баталгаажуулж түрээсийн гэрээг сунгах, эсвэл цуцлах асуудлыг боловсруулан удирдлагад танилцуулах,

4.1.3 ХХАА-н сайдын 2016 оны А-83 дугаартай тушаалаар олгосон 4 ширхэг “Усны өрөмдлөгийн машины иж бүрдэл”-ийг хүлээн авсан Сүхбаатар, Дундговь, Дорнод, Хөвсгөл аймгийн Засаг дарга нараас эдгээр машинуудын түрээсийн гэрээ, өмчийн

ашиглалт, хамгаалалттай холбоотой асуудлаар тодруулга, албан мэдээлэл авах ажлыг 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор тус тус зохион байгуулах,

#### **4.2. “Махны цэвэр үүлдрийн үхэр импортлож, үржлийн аж ахуй эрхлэх” төслийн талаар**

4.2.1 ХХААХҮЯ-ны МААБХЗГ-аас “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Франц улсаас импортлон авсан “Махны чиглэлийн цэвэр үүлдрийн үхрийг үржүүлж, хамтран ашиглах тухай” гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан мэдээг гаргах, Мал хамгаалах сангийн дансан дахь 2.0 тэрбум төгрөгийн авлага гэдгийг “Гацуурт” ХХК-ийн аж ахуйд гэрээний дагуу өсгөн үржүүлж байгаа “limousin”, “Montbeliarde” үүлдрийн 176 үхэр байдлаар тусгаж, үхрийн бойжилт, үржүүлгийн ажил, өвс, тэжээлийн хангамж, нэг үхэрт ногдох зардал зэргийн талаар гэрээт талууд тайлан бэлтгэж 12 дугаар сарын 20-ны дотор Аудитын хорооны даргад танилцуулахыг,

4.2.2 “Хонь бордох загвар аж ахуй бий болгох” төсөлд дэмжлэг үзүүлэх тухай АГГ-140520/03-045 дугаартай гэрээний 3.2-д заасны дагуу 1000 толгой хонийг барьцаа болгон Мал хамгаалах санд бүртгэж авахдаа байгаа газарт нь очиж нэг бүрчлэн тоолж, бүртгэж хүлээж аваагүй хариуцлага алдсан МХС-ийн удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож, хонийг 2018 оноос гэрээний дагуу төвлөрүүлэх,

#### **ТАВ. МАЛ ХАМГААЛАХ САНД**

5.1 ХХАА-н Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах төсвийн байгууллагуудаас олон удаа зээл авч зээлийн өрийн төлбөрийг гүйцэтгээгүй “Бага-Өлгий” ХХК, “Ургац хүдэр” ХХК, “Монтаримал” ХХК-иудад үүссэн өрийг 2016 оны 12 сарын 20-ны дотор барагдуулж Дотоод аудитын хороонд танилцуулах,

5.2 МХС-ийн агуулахад 2011 оноос хойш борлогдоогүй зарим бараа материал, эвдэрхий тоног төхөөрөмжүүдийг (Өвс хаман боогч, Ногоон тэжээл хэрчигч машин, Эрдэнэшишийн үр, 5 ширхэг үрлүүр, ширхэг ногоон тэжээл үйлдвэр) актлах, худалдах, хуваарилах, түрээсээр эзэмшүүлэх арга хэмжээ авч хэрэгжилтийг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан Дотоод аудитын хороонд танилцуулах,

5.3 МХС-аас 2007-оноос 2013 онуудад гэрээгээр олгосон 12.0 сая төгрөгийн 15 толгой бодон, 97.6 сая төгрөгийн 150 толгой мэгж, 3 бух, 69 толгой үхэр буюу нийт дүнгээрээ 85.9 сая төгрөгийн мал амьтдыг эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийг тогтоож, мал амьтдын тооллого явуулж, гэрээг шинэчлэх ажлыг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулах, олохгүй байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийг шүүх, хяналтын байгууллагад шилжүүлэх 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах, хэрэгжилтийг далаарх мэдээллийг Дотоод аудитын хороонд танилцуулах,

5.4 Сонгон шалгаруулсан зээлийн төслүүдийн үр дүн, үр ашгийн талаар судалгаа хийж хяналт тавих, тайлан бэлтгэж удирдах дээд байгууллагад танилцуулж байх,

5.5 Зээлдэгчдийн нэгдсэн бүртгэл бий болгох, эрсдлийг тооцон нэг зээлдэгчдэд олон удаагийн зээл олгохгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх, хугацаа хэтэрсэн бүх зээлийн гэрээг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлж авлагыг бууруулах,

5.6 Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 дугаар тушаал “Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-ыг үндэслэн “Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулан баталгаажуулж холбогдох данснуудын харьцааг дэлгэрэнгүй тусгах, найдваргүй авлагын хасагдуулгын дансыг бий болгох,

5.7 МХС нь бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах ажлын хэсэгт ажиллаагүй тохиолдолд зээлийн болон түрээсийн гэрээ байгуулахгүй байх, нягтлан бодох бүртгэлд бүртгэхгүй байх,

5.8 Тайланд дурьдсан болон МХС-аар дамжуулан олгосон тоног төхөөрөмж, жижиг үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж үнэлгээ хийх, гэрээний үүргийн хугацаа хэтэрсэн асуудлуудыг шүүхэд шилжүүлэх ажлыг зохион байгуулах,

5.9 Төрийн албаны зөвлөлөөс баталсан үр дүнгийн гэрээний үлгэрчилсэн загварыг ашиглан ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулж гэрээний биелэлтийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж хагас, бүтэн жилээр дүгнэж, урамшуулах, хариуцлага тооцох арга хэмжээг хэрэгжүүлэх,

5.10 Сангийн үйл ажиллагааг зохицуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулахад хяналт тавих үүрэг бүхий “Удирдах зөвлөл”-ийн хурлыг тогтмол хийж ажлаа тайлагнаж, үр дүнг танилцуулах,